



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 02 өдөр

Дугаар А/91

Мөрөн сум

Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох,  
олгох, сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.5, 14 дүгээр зүйлийн 14.1.1, 16 дугаар зүйлийн 16.2.5, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит бус XII хуралдааны 02 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 90 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэдийн өргөдөл, хүсэлт, суманд ажиллаж байгаа ажлын хэсгийн дүгнэлт, сумын Засаг даргын саналыг харгалзан согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүчингүй болгох жагсаалтыг 1 дүгээр, олгох жагсаалтыг 2 дугаар, сунгах жагсаалтыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газар (Д.Түмэнбаяр), Цагдаагийн газар (Цагдаагийн дэд хурандаа Т.Ганхуяг), холбогдох сумдын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

3. Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль болон бусад хууль тогтоомж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 90 дүгээр тогтоолоор батлагдсан журмыг мөрдөж, аймгийн Засаг даргын 2016 оны А/10 дугаар захирамжаар батлагдсан цагийн хязгаарт нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулахыг согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үүрэг болгосугай.

4. Хүчингүй болгосон тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хурааж, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэст хүргүүлэн, татварын албанд мэдэгдэхийг Мөрөн сумын Засаг дарга (Б.Батбаяр)-д даалгасугай.


5. Энэхүү захирамжийг эс зөвшөөрвөл оролцогчид мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдол гаргах эрхтэй болохыг дурьдсугай.

6. Тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийг аймгийн орон нутгийн орлогод төвлөрүүлж, тооцон ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Базар), захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай) нарт тус тус даалгасугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын 2022 оны 03  
дугаар сарын 02-ны өдрийн А/З/..  
дугаар захирамжийн 1 дүгээр  
хавсралт




СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ТҮҮГЭЭР ҮЙЛЧЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ЖАГСААЛТ

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн		Объектийн нэр, үйлчилгээний чиглэл	Тусгай зөвшөөрөл олгосон огноо, шийдвэр, гэрчилгээний дугаар	Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон үндэслэл
	Оршин суугаа хаяг	Иргэн, аж ахуй нэгжийн нэр			
1	Эрдэнэбулган сум 4-р баг	Цэвээн Мөнхжаргал РЭ67100877	"Шинэ хүнс" Хүнсний дэлгүүр Эрдэнэбулган сум 4-р баг	2019.12.02 А/532-1-2 Г-1003	Тусгай зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан.

---oOo---

*Handwritten signature*

Аймгийн Засаг даргын 2022 оны 03  
дугаар сарын 02-ны өдрийн А/7/..  
дугаар захирамжийн 2 дугаар  
хавсралт



СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ТҮҮГЭЭР ҮЙЛЧЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ЖАГСААЛТ

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн		Нэр, байршил	Тусгай зөвшөөрлийн төрөл
	Оршин суугаа хаяг	Иргэн, аж ахуй нэгжийн нэр		
1	Эрдэнбулган сум 4-р баг	Гомбо Отгончимэг РП76031163	"Баян-Ундрах" Хүнсний дэлгүүр Эрдэнэбулган сум 4-р баг	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах

---oOo---

*Handwritten signature*



Аймгийн Засаг даргын 2022 оны 03  
дугаар сарын 02-ны өдрийн А/ 21.  
дугаар захирамжийн 3 дугаар  
хавсралт



СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ТҮҮГЭЭР ҮЙЛЧЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦАА СУНГАСАН ЖАГСААЛТ

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн		Нэр, байршил	Тусгай зөвшөөрлийн төрөл
	Оршин суугаа хаяг	Иргэн, аж ахуй нэгжийн нэр		
1	Мөрөн сум 10-р баг 10-38-1	Дашдаваа Эрдэнэчимэг РЭ73011560	"Уранмандал-1" Хүнсний дэлгүүр Мөрөн сумын 10-р баг 10-38-1	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах
2	Мөрөн сум 5-р баг	Баасанжав Баянбилэг РВ73091555	"Өрнөх" Хүнсний дэлгүүр Мөрөн сум зах 5-р баг	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах
3	Цагааннуур сум 1-р баг	Самдан Лхагвасүрэн РЦ62122577	"Цагааннуур" Хүнсний дэлгүүр Цагааннуур сумын төвд	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах
4	Галт сум 5-р баг	Дашвандан Эрдэнэбат РД78062618	"Таван-Эрдэнэ" Хүнсний дэлгүүр Галт сумын төвд	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах
5	Баянзүрх сум 5-р баг	Норовжий Баасанжав РВ64081401	"Тэнгэрэн" Хүнсний дэлгүүр Баянзүрх сумын төвд	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах
6	Чандмань-Өндөр сум 4-р баг	"Тэнгэрийн гурван марал" ХХК РД4142578	"Гурван марал" Хүнсний дэлгүүр Чандмань-Өндөр сумын төвд	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах
7	Цэцэрлэг сум 2-р баг	Дамдин Дуламрагчаа РС78082645	"Хямд" Хүнсний дэлгүүр Цэцэрлэг сумын төвд	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах
8	Алаг-Эрдэнэ сум Манхан баг	Лувсангомба Давхарбаяр РА76010911	"Идэр" Хүнсний дэлгүүр Алаг-Эрдэнэ сумын төвд	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах
9	Алаг-Эрдэнэ сум Манхан баг	Гомбо Түмэнбаяр РА71051415	"Оргил" Хүнсний дэлгүүр Алаг-Эрдэнэ сумын төвд	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах
10	Тариалан сум Бадрах баг	Адъяа Хөвсгөлдалай РЙ70122519	"Дэвшил" Хүнсний дэлгүүр Тариалан сумын төвд	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах
11	Тариалан сум Мандал баг	Равдан Саранхүү РЙ82013103	"Сондор" Зоогийн газар Тариалан сумын төвд	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх

---oOo---

*Handwritten signature*